

ГАМШГААС ХАМГААЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО,
ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ҮЕ ШАТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2016.02.03

Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл, Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийн стратеги зорилтуудыг хэрэгжүүлэх талаар 2011-2015 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Нэг. "Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах" стратегийн зорилтын хүрээнд:

1.1. Иргэдэд түшиглэсэн гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлэх:

Иргэдэд түшиглэсэн гамшгийн менежментийг хөгжүүлэх зорилгоор ОБЕГ, Гамшиг судлалын хүрээлэн "Гамшгийн эсрэг үндэсний төв" ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийг байгуулан ажиллаж байна.

НҮБХХ-өөс хэрэгжүүлж байгаа "Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах нь" МОН/13/301 төслийн хүрээнд иргэдэд түшиглэсэн гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлэх чиглэлээр 2013-2015 онд дараах гол гол ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: ОБЕГ-ын даргын 2015 оны А/132 тоот тушаалаар "Сумын гамшгаас хамгаалах жишиг төлөвлөгөө", Булган аймгийн Сэлэнгэ сумын ИТХ-ын шийдвэрээр "Иргэдийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах "Сэлэнгэ хөтөлбөр"-ийг тус тус батлуулан, хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд иргэдийн оролцоотой орон нутгийн аюулын зураглал, эмзэг байдал, чадавхийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, ган, зудын гамшгийн эрсдэлийг бууруулж, малын тэжээл бэлтгэх, даршлах арга, технологи эзэмших, масс мессеж үйлчилгээг ашиглах зэрэг сургалт, дадлагыг удаа дараа зохион байгуулж, 4 сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэв. "Гамшгаас хамгаалах сургалтын хөтөлбөр"-ийн чиглэлээр нийт 16 сурах бичиг, гарын авлага боловсруулав. Орон нутгийн малчид, ард иргэдэд хүргэх цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ, аюулт үзэгдлийн талаарх мэдээлэх масс мессеж үйлчилгээ үзүүлэх програм, техник хэрэгслээр 21 аймгийн 319 сумыг хангаж, ард иргэдэд цаг алдалгүй сэрэмжлүүлэх мэдээг хүргэж ажилласан. Иргэдийн оролцоотой 880 айлын өвөлжөө, хаваржааг хээрийн түймрээс хамгаалах зурвас байгуулсан.

"Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний дэд хөтөлбөр"-ийг Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 35 дугаар тушаалаар батлуулж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Дэлхий Зөн Монгол Олон улсын байгууллагатай хамтран улсын хэмжээнд 167 сургагч багш бэлтгэн тэднээр дамжуулан 21 аймгийн 297 сум, 114 баг, хороог хамруулан нийт 301912 орчим хүнд сургалт явуулсан. Сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах 76 удаагийн сургалтад 406 нийгмийн ажилтан, 24352 багш, сурагчдыг хамруулсан. Мөн 1194 аж ахуйн нэгж байгууллагын сургалт хийж 577871 ажилтан, албан хаагчдыг хамруулав. Уг хөтөлбөрийн Дэлхийн зөн Монгол ОУБ-аас 1,5 тэрбум төгрөгөөр, орон нутгийн ЗДТГ, Онцгой байдлын байгууллагаас 573,4 сая төгрөгийн санхүүжилт гаргаж амжилттай хэрэгжүүлж дуусгав.

Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй "Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллыг чадавхжуулах, хүүхэд төвтэй бэлэн байдлын асуудлыг бэхжүүлэх нь" төслийг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн багш нарын бүсчилсэн сургалтыг Улаанбаатар хот, Өмнөговь, Өвөрхангай, Хэнтий, Баян-Өлгий аймгуудад зохион байгуулсан.

Мерси кор монгол ОУБ-тай хамтран "Гамшгийн аюулыг тооцёё, эртлэн төлөвлөө, эрсдэлгүй давъя" сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтыг 2015 оны 09 дүгээр сарын 02-23-

ны өдрүүдэд бүсчилсэн хэлбэрээр Улаанбаатар хот, Баянхонгор, Завхан, Увс аймгуудад зохион байгуулан явуулсан.

“Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 303 дугаар тогтоолоор батлуулж, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, холбогдох талуудаар хэлэлцүүлж, санал авахаар ажиллаж байна.

1.2.Сумын түвшинд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төрийн захиргааны албан хаагчийг ажиллуулах:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд суманд гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтанг сумын Засаг даргын Тамгын газарт ажиллуулах асуудлыг тусгасан.

2015 онд “Сумын түвшинд гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан хаагчийг ажиллуулах үндэслэл” сэдэвт захиалгат судалгааны ажлын хүрээнд ГСХ-ээс Монгол Улсын 21 аймгийн нийт сумдад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тоо, төрөл, тэдгээрээс учирсан хохирол, амь насаа алдсан хүний тоо зэрэг үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, улсын хэмжээнд нийт эхний ээлжинд 69 суманд гамшгаас хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх албан хаагчийг томилон ажиллуулах шаардлагатай байгаа тухай судалгааг гаргав.

1.3.Төв, орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллага, түүнчлэн хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах арга хэмжээнд оролцох оролцоог нэмэгдүүлж, түншлэл, хамтын ажиллагаа, салбар дундын удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 81 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулж, төрийн байгууллага, мэргэжлийн байгууллагуудын гамшгийн үед ажиллах удирдлага, зохион байгуулалт, түншлэл, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлээ.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах арга хэмжээнд оролцох оролцоог нэмэгдүүлэх үүднээс улсын хэмжээнд 62 орон нутгийн гамшгаас хамгаалах алба, 161 мэргэжлийн анги, 268 сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, гамшгийн үед хамтран ажиллах талаар үүрэг даалгавраар ханган ажиллаж байна.

ОБЕГ нь үндэсний 14 төрийн бус байгууллага, Дэлхийн зөн-Монгол ОУБ, МУЗН, Мерси кор ОУБ, Дэлхийн банк, Азийн гамшгийн бэлэн байдлын төв, Японы хүүхдийг ивээх сан зэрэг Олон улсын байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Орон нутгийн Онцгой байдлын газруудаас Дорнод, Дундговь, Дорноговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв аймгийн ОБГ-ууд аймгийн ИТХТ-ийн шийдвэрээр аймгийн түншлэл хамтын ажиллагааны зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Мөн орон нутагт үндэсний аюулгүй байдлын хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн тусгай байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллаж байна.

1.4.Болзошгүй гамшгийн аюулыг бууруулах арга хэмжээнд олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх:

2015 онд ОБЕГ нь төрийн болон төрийн бус 14 байгууллагатай гамшгаас хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулж, түүний дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон улсын байгууллагууд (НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн зөн Монгол, Японы Хүүхдийг ивээх сан, ЖАЙКА, КОЙКА, АДРА, Азийн гамшгийн бэлэн байдлын төв, Азийн

гамшгийн аюулыг бууруулах төв, Австралийн Улаан загалмайн нийгэмлэг, Азийн галын байгууллагын дарга нарын гэх мэт) -тай нягт хамтран ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр “гамшгаас хамгаалах сайн дурынхны ажиллах нийтлэг журам”-ын төслийг боловсруулж байна.

1.5.Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлын улсын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах:

Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан яам, агентлагуудаас ирүүлсэн саналыг тусган Монгол Улсын Шадар сайдын Ажлын албанд нууц албан бичгээр хүргүүлэн Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор “Монгол Улсын гамшгийн хамгаалах төлөвлөгөө”-г батлуулав.

1.6.Төв, орон нутгийн томилгоот гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг тогтоох:

“Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, шалгалт зохион байгуулах, үнэлэх журам”-ын төслийг боловсруулж Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2014 оны А/350 тоот тушаалаар батлуулсан.

1.7.Гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг гамшгаас хамгаалах арга хэмжээнд нэвтрүүлэх:

ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс гамшиг судлалын чиглэлээр 2012 онд 62, 2013 онд 68, 2014 онд 71, 2015 онд 83 судалгааны тайланг гаргаж эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Судалгааны ажлын 40% гамшгаас хамгаалах судалгаа, 44% гамшгийн эрсдэл судлал, 13% гамшгийн удирдлага судлал, 3% технологи инновацийн чиглэлээр хийгдсэн байна.

Мөн гамшгаас хамгаалах арга хэмжээнд дараах судалгааг нэвтрүүлэхээр судалгааны тайлан боловсруулсан. Үүнд:

1. “Хөөс үүсгэгчийг объектын гал түймэрт ашиглах боломж”,
- 2.“Ой, хээрийн бүс нутагт хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зурвас татах техник технологийг нэвтрүүлэх” зэрэг болно.

Гамшиг судлалын шинжлэх ухааны хөгжилд гамшгийн эрсдэлийг бууруулах дэвшилтэт техник технологийг өргөнөөр ашиглах хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүрээлэнгийн бүтцийг шинэчлэн ОБЕГ-ын даргын 2015 оны Б/46 тоот тушаалаар Эрдэм шинжилгээ, инновацийг хариуцсан нэгж байгуулан ажиллаж байна.

1.8.Төв, орон нутгийн төрийн байгууллага, хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлж, гамшгийн бэлэн байдлыг хангахад шаардлагатай эд материал, аврах багаж, техник хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх:

Төв, орон нутгийн төрийн байгууллага, хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох оролцоог тодотгох, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах “Орон нутгийн гамшгаас хамгаалах албаны ажиллах журам”-ыг боловсруулж ОБЕГ-ын даргын 2013 оны А/865 дугаар тушаалаар батлуулав.

2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 18.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий аврах, гал унтраах зориулалттай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагад хуваарилан өгсөн. Ази-Европын 11 дэх дээд түвшний уулзалт /АСЕМ/-ыг 2016 онд Монгол Улсад зохион байгуулахтай холбогдуулан аюулгүй байдлыг хангах чиглэлээр Онцгой байдлын албанд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн тооцоо, зориулалт, үнийн судалгааг гаргаж АСЕМ-ыг зохион байгуулах хороонд хүргүүлсэн.

Хоёр."Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах" стратегийн зорилтын хүрээнд:

2.1. Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх:

2012 онд "Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа" сэдэвт судалгааны төслийн хүрээнд ГСХ-ээс Монгол орны байгалийн болон техногенийн гаралтай гамшгийн стратегийн эрсдэлийн үнэлгээ болон таамаглал гаргаж, эдгээрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагавар, хор хохирлыг даван туулах бодлогын хүрээнд болзошгүй стратегийн эрсдэлийг тооцож байх арга зүйн механизмыг тодорхойлсон санал, зөвлөмжийг боловсруулж, шийдвэр гаргагчдад танилцуулсан. Эдгээр эрсдэлийн үнэлгээний тайлангууд нь Нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үндэслэл болсон.

2.2.Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг учруулж болзошгүй байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн аюул, төв, орон нутгийн газар зүйн байршил, эдийн засаг, нийгмийн онцлог, хөгжлийн бодлого, олон улсын жишиг үнэлгээний аргачлалд тулгуурлан боловсронгуй болгох:

2012 онд Ус, цаг уур, орчны судалгаа, шинжилгээний хүрээлэнтэй хамтран JAXA олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр "Ой, хээрийн түймрийн эрсдэлийн зургийг олон хэмжүүрт анализийн арга дээр тулгуурлан гаргах нь" сэдвийн хүрээнд MODIS хиймэл дагуулийн мэдээнд тулгуурлан Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн ой, хээрийн түймрийн эрсдэлийг зурагласан. Энэ судалгаа нь ой, хээрийн түймрийн эрсдэлтэй бүсийг зайнаас тандан судлал, газарзүйн мэдээлийн системийг ашиглан тогтоож байгаагаараа ач холбогдолтой болсон.

Австралийн Улаан загалмай нийгэмлэгийн сайн дурын ажилтантай хамтран эрсдэлийн удирдлага, эрсдэлийн үнэлгээний талаар мэдээлэл солилцож, анхан шатны цогц мэдлэгийг олгуулах сургалтыг ОБЕГ, ГСХ, Хууль сахиулахын их сургуулийн Онцгой байдлын сургуулийн албан хаагчдад 2014 оны 04 дүгээр сард зохион байгуулж, уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх тухай хичээлийг оруулав.

"Сумын түвшинд олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ерөнхий аргачлал"-ыг боловсруулж, энэхүү аргачлалаа нийт 5 аймгийн 7 суманд орон нутгийн иргэдийг хамруулан туршсан.

2.3.Болзошгүй гамшгийн эрсдэл, түүний нөлөөллийн талаархи статистикийн мэдээ, өгөгдөхүүнийг цуглуулах стандартыг тогтоох, гамшгийн мэдээллийн сангийн үйлчилгээг боловсронгуй болгох:

Гамшгийн сүүлийн 30 жилийн мэдээллийг цуглуулж, гамшгийн мэдээ бүртгэх хүснэгтийг гаргаж батлуулсан.

2015 онд ОБЕГ нь НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах газар (UNISDR), Азийн гамшгийн бэлэн байдлын төв (ADPC)-тэй хамтран "Монгол Улсын гамшгийн хохирлын мэдээллийн санг бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх чадавхийг сайжруулах" төслийг хэрэгжүүлж, Монгол Улсад тохиолдсон гамшгийн хохирлыг он, төрөл зүйлээр ялгаж НҮБ-ын DesInventar вэб хуудсанд оруулж байна.

2.4.Бүс нутгийн болон хил дамнасан болзошгүй гамшгийн эрсдэлийг үнэлэх, байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу мэдээлэл солилцох:

2014 онд "Хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэл"-ээр хамтарсан уулзалтыг Хөвсгөл, Булган, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар,

хэлтсүүд ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Онцгой байдал, иргэний хамгаалалтын ерөнхий газартай хамтран Сэлэнгэ аймагт, Увс, Завхан, Ховд аймгийн Онцгой байдлын газар, хэлтсүүд ОХУ-ын Бүгд Найрамдах Тува Улсын Онцгой байдал, иргэний хамгаалалтын ерөнхий газартай хамтран, ӨМӨЗО-ны Хөлөн Буйр аймгийн зүүн, баруун барга хошуутай Сүхбаатар, Дорнод аймгийн ЗДТГ хамтарсан уулзалтыг зохион байгуулж хамтран ажиллах чиглэлийг ярилцсан.

“Хил орчмын ой, хээрийн түймрийн талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хил орчмын бүсийн ой, хээрийн түймэртэй тэмцэх тухай” Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан комиссын II уулзалтыг 2014 оны 08 дугаар сард Монгол Улсад зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодотгов.

Монгол Улсын Засгийн газар ОХУ-ын Засгийн газар хоорондын ойг түймрээс хамгаалах тухай хэлэлцээрийн төслийг боловсруулан, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В. Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр үзэглэсэн.

“Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах” тухай Монгол Улсын Засгийн газар ОХУ-ын Засгийн газар, хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол-Оросын хамтарсан комиссын XIII хуралдааныг 2014 оны 10 дугаар сард Улаанбаатар хотод XIV хуралдааныг 2015 оны 4 дүгээр сард ОХУ-ын Москва хотод тус тус зохион байгуулсан.

2015 онд Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Дархан-Уул аймгуудын Онцгой байдлын газар, ОХУ-ын ОБЯ-ны Бүгд Найрамдах Буриад Улс дахь Ерөнхий газар хоорондын 2015 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө батлах ажлын уулзалт, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын Онцгой байдлын газар, ОХУ-ын ОБЯ-ны Өвөрбайгалын хязгаар дахь Ерөнхий газар хоорондын 2016 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлах уулзалтыг Хэнтий аймагт тус тус зохион байгуулав.

Гал түймэртэй тэмцэх газрын даргаар ахлуулсан 8 албан хаагчид БНХАУ-ын Ойн улсын хорооны Ойн түймэртэй тэмцэх газар, түүний салбар ангиуд, ойн түймэр унтраах багаж хэрэгслийн үйлдвэрүүдтэй танилцах аялал, Монгол Улс ОХУ-ын Засгийн газар хоорондын хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ээлжит 3 дугаар хуралдааныг тус тус хамтран зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлов.

Мөн 2015 оны 03 дугаар сарын 13-18-нд Япон Улсын Сендай хотноо зохион байгуулагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн гуравдугаар бага хурал”-д Монгол Улсын Шадар сайд тэргүүтэй төлөөлөгчид оролцсон бөгөөд тус хурлаас батлан гаргасан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2.5.Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх, ардын уламжлалт арга ухааныг түгээн дэлгэрүүлэх:

Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 35 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшгаас хамгаалах талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, ардын уламжлалт арга ухааныг түгээн дэлгэрүүлэх зорилгоор улсын хэмжээнд 1915 удаа 346555 иргэнийг хамруулан сургалт зохион байгуулсан.

Тус дэд хөтөлбөрийн хүрээнд 2013-2015 онд олон улсын байгууллагуудтай (ДЗМОУБ, Японы хүүхдийг ивээх сан, Мерси кор монгол ОУБ, Азийн гамшгийн бэлэн байдлын төв, НҮБХХ-ийн Мон 13/301 төсөл, Дэлхийн банк зэрэг) хамтран 988 сургагч багш бэлтгэн нарт “Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ардын уламжлалт арга ухаан” сэдвээр хичээлийн конспект бэлтгэн сургагч багш нарт хүргүүлсэн.

Мөн 2012, 2013, 2014 онуудад “Хороодын гамшгаас хамгаалах томилгоот бүрэлдэхүүн, сайн дурынхны үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэх” сургалтыг 234 хэсгийн ахлагч болон сайн дурынханд, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлага олгох сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний хамгаалагчид, өндөр настан, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд хийж, олон улсын гамшгийн эрсдэлийг бууруулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг нийслэл, 21 аймагт зохион байгуулж, “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийг бэлтгэн “UBS”, МҮОНТ, ТВ-9 телевизээр 14 хоногт 1 удаа 20 минутаар давталттайгаар дохионы хэлний орчуулгатайгаар иргэдэд хүргэж байна.

Гурав.”Гамшгийн нэр томещъёоны суурь ойлголт, төрийн болон хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах чиг үүрэг, тогтолцоо, гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох” стратегийн зорилтын хүрээнд

3.1. Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Онцгой байдлын албаны тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулж, Монгол Улсын Шадар сайд, Хууль зүйн сайдаар батлуулав.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн чуулганаар батлуулав.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулахаар ажиллаж байна.

3.2. Аврагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах:

Онцгой байдлын албаны тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулж, Монгол Улсын Шадар сайд, Хууль зүйн сайдаар батлуулав.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан, Онцгой байдлын албаны тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж батлуулахаар ажиллаж байна.

3.3. Гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, давхар даатгалын тухай хуулийн төсөл боловсруулах

Гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, давхар даатгалын тухай хуулийн төсөл нь судалгааны шатанд явж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрийн 2 дахь шатанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа болно.

3.4. Гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дотоодын хүмүүнлэгийн тусламж, олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, зохицуулах, зогсоох асуудлыг 1 бүлэг 4 зүйл болгож тусгасан

Дөрөв.”Аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологийг нэвтрүүлж, мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх арга замыг боловсруулж, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулах” стратегийн зорилтын хүрээнд:

4.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зайнаас тандан судлах, газар зүйн мэдээллийн системийг нэвтрүүлэх:

Онцгой байдлын ерөнхий газраас НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн хамтын комисстой хамтран 2014 оны 06 дугаар сард Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд Сансрын технологи, газарзүйн мэдээллийн системийг нэвтрүүлэх нь сэдэвт сургалтыг Онцгой байдлын албаны Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулав.

Онцгой байдлын ерөнхий газар, Газрын харилцаа геодези зурагзүйн газар Монгол Улсын үндэсний оронзайн мэдээллийн дэд сан байгуулах ажлыг дэмжих, Онцгой байдлын албанд газарзүйн мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2014 онд хамтын ажиллагааны гэрээг байгуулж ажиллаж байна. Тус гэрээний хүрээнд онцгой байдлын албаны нийт 11 албан хаагчийг Газарзүйн мэдээллийн системийн анхан, дунд шатны сургалтад хамруулав.

4.2.Эрсдэлийн зураглал, мэдээллийг боловсруулах, дамжуулах техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх:

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны KOICA байгууллагаас хэрэгжүүлсэн “Монгол улсын гамшигтай тэмцэх чадавхийг сайжруулах” төслийн 2 шат буюу тоног төхөөрөмжийг сайжруулах ажлын хүрээнд тус байгууллагаас нийслэлийн хүрээний онцгой байдлын албаны газар, хэлтсийн удирдлагууд нийт 25 хүнд онцгой байдлын албаны газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Мөн тус төслийн хүрээнд Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын албан хэрэгцээнд нийт 5 ширхэг иж бүрэн компьютерээр хангасан бөгөөд зураглал хийх, мэдээлэл боловсруулах зэрэгт ашиглаж байна.

МТШХХГ, Япон Улсын Эдийн засаг, аж үйлдвэрийн яамны Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Японы сансрын системийн хөгжил, ашиглалтыг дэмжих байгууллагатай хамтран байгуулсан “Монголд тандалт судалгааны хиймэл дагуулын системийг танилцуулах сургалт”-д нэг албан хаагчийг оролцуулав.

Онцгой байдлын албан хаагчдад зориулсан газарзүйн мэдээллийн систем зайнаас тандан судлалын гарын авлага, ном гарсан.

Монгол орны 1:100000-ны масштабын тоон мэдээллийн сан бий болсон.

Вебэд суурилсан гамшгийн оронзайн мэдээллийн санг хийх ажлын хүрээнд 2005-2014 оны гамшгийн мэдээллийг оронзайн мэдээлэлтэй холбох ажил 90 хувьтай хийгдэж байна.

2010 онд байгуулсан ОБЕГ, Япон улсын Агаар сансрын судалгаа шинжилгээний агентлаг хоорондын холбооны зориулалт бүхий “Winds” хиймэл дагуулын антенныг суурилуулж ашиглах гэрээний санамж бичгийг дагуу 2015 оны 09 сарын 26-30-ны өдрийн хугацаанд Япон Улсаас хүрэлцэн ирсэн 2 инженерийн туслалцаатайгаар хиймэл дагуулын антенны дотор төхөөрөмжийг засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ.

4.3.Болзошгүй гамшгийн аюулын талаар хүн амд түгээх зарлан мэдээллийн техник хэрэгслээр хангаж, мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх арга замыг боловсронгуй болгож, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулах:

Эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулах үйл ажиллагааны хүрээнд “Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах” төслийн 1, 2 дугаар шатанд Улаанбаатар хотын хэмжээнд Зарлан мэдээлэх дуут дохиоллын нийт 60 цамхаг, өргөн нэвтрүүлгийн EBS төхөөрөмжийг 4ФМ-ийн газарт, Булган, Дундговь, Төв, Сэлэнгэ нийт 4 аймгийн 7 сумын 12 цэгт газар хөдлөлтийн мэдрэгч төхөөрөмжийг 2012-2014 онд тус тус суурилуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зарлан мэдээлэх дохио дамжуулах дарааллыг гаргаж, жил бүрийн 03 дугаар сарын 4 дүгээр Пүрэв гаригт 16:00-17:00 цагийн хугацаанд дуут дохиоллын 60 цамхаг, 3 телевиз, 9 FM радио, үүрэн телефоны сүлжээгээр дамжуулан гамшгийн аюулын тухай зарлан

мэдээллийн дохиог 4 удаагийн давталттайгаар монгол, англи хэлээр иргэд, олон нийтэд хүргэж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж байна.

2015 онд зарлан мэдээллийн системийн туршилтыг 92 удаа, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газруудтай холбогддог богино долгионы давтамжуудыг сольж, сонсголын түвшинг сайжруулах туршилт судалгааг 3 удаа, зарлан мэдээллийн багц мессеж дамжуулах системийн туршилтыг “Мобиком” ХХК, “Юнител” ХХК-ийн сүлжээнд нийт 63 удаа, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвөөс цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ, мал амьтны гоц халдварт өвчний тухай сэрэмжлүүлэг, газар хөдлөлт болсон тухай сэрэмжлүүлэг мэдээ зэргийг дуут дохиоллын 60 цамхаг, цахим дэлгэц, өргөн нэвтрүүлгийн 3 телевиз, 2 үүрэн холбооны 2G сүлжээний нийт хэрэглэгчдэд мессеж, урт болон богино долгионы 9 FM радио нэвтрүүлэгээр нийтдээ 1450 орчим удаа, цахим дэлгэцээр 1160 цаг тус тус ард иргэдэд зарлан хүргэв.

Тав.Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхийг бэхжүүлэх стратегийн зорилтын хүрээнд:

5.1.Аврагчийг мэргэжлийн сургалтын төвөөр бэлтгэх, мэргэшүүлэх:

Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуульд 2013 онд 246, 2014 онд 235 аврагч, гал сөнөөгч жолооч бэлтгэж, 2015 оны 01 дүгээр сард аврагч-гал сөнөөгч мэргэжлээр 124, жолоочоор 55, 06 дугаар сард аврагч-гал сөнөөгч мэргэжлээр 99 хүн бэлтгэж төгссөн.

2015 оны байдлаар нийтдээ тус сургуулийг 278 аврагч-гал сөнөөгч, жолооч суралцаж төгссөн байна.

5.2.Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох:

Хууль сахиулахын их сургуулийн Онцгой байдлын сургуульд гамшгаас хамгаалах мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж жил бүр 30-35 офицер албан хаагчийг онцгой байдлын ажил-эрх зүй мэргэжлээр төгсгөж байгаа бөгөөд 2015 оны 06 дугаар сард бакалаврын зэрэгтэй төгссөн 30 сонсогчдод онцгой байдлын дэслэгч цол олгож томилгоожуулав.

Тус сургуулийн Онцгой байдлын сургууль болон Ахлагчийн сургуульд 2014-2015 оны хичээлийн жилд төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагаас 18 албан хаагч, ерөнхий боловсролын сургуулиас 67 иргэн, Удирдлагын сургуульд 8 албан хаагч элсэн суралцаж байна.

Төрийн зардлаар болон тэтгэлэгт хөтөлбөрөөр Тайландын Вант Улсад 2, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2, Австрали Улсад 1 албан хаагч тус тус суралцаж байна. ОХУ-ын Иргэний хамгаалалтын академи, Гал эсэргүүцэх албаны академид элсэн суралцах албан хаагчдын тоо 2012 онд 7, 2013 оноос хойш 11 болж 45 хувиар нэмэгдсэн. 2014 онд 11, 2015 онд 10 албан хаагч элсэн суралцаж байна.

5.3.Аврах, гал унтраах анги, бүлэг, бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай аврах ажлын багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тусгай зориулалтын машин механизмын стандарт, норм, нормативыг боловсруулах:

“Гал унтраах анги, хэсэг, Аврах нэгжид тавигдах шаардлага” MNS 6412:2013 стандартыг Стандарт хэмжил зүйн газраар 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр батлуулж 2014 оны 02 дугаар сараас мөрдөн ажиллаж байна.

Гал унтраах даралтын хоолой, Гал унтраах аврах ажиллагаанд ашиглах аврах олсны стандартыг боловсруулан батлуулахаар Стандартчилал хэмжил зүйн газарт хүргүүлсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2014 оны 37 дугаар тушаалаар томилсон ажлын хэсэг “Эрэн хайх, аврах нэгжийн тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн хангалт эдэлгээний хугацаа түүнд тавигдах шаардлага

стандарт"-ын төсөл боловсруулж, НҮБ-ын Эрэн хайх, аврах олон улсын зөвлөлдөх бүлгийн үнэлгээний багаас 2014 онд гаргасан тайлан, зөвлөмжид тулгуурлан стандартын төслийг олон улсын эрэн хайх, аврах багт тавигдах, бусад улсын стандарттай харьцуулах судалгаа хийгдэж байна.

ОБЕГ-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд "Аврах анги, салбар, бүлгийн аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн стандарт" боловсруулахаар тусган ажиллаж байна.

5.4.Эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй газар хөдлөлт, үер, цацраг, химийн хорт болон аюултай бодисын хордуулалт, бусад гамшгийн хор уршгийг арилгах аврах ажлын зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах:

2012-2014 онд 11.4 тэрбум төгрөгөөр 56 нэр төрлийн аврах ажлын зориулалттай техник тоног төхөөрөмж, 11.3 тэрбум төгрөгийн 105 нэр төрлийн гал унтраах болон аврах ажлын зориулалттай техник, тоног төхөөрөмж худалдан авч ашиглаж байна.

Төрийн өмчийн хорооны 2014 оны 3/903 тоот албан бичиг болон 2015 оны 3/184 тоот албан бичгийн дагуу "Газар хөдлөлтийн гамшгийг урьдчилан анхааруулах систем байгуулах" төслийн хүрээнд 9,4 тэрбум төгрөгийн өртөг бүхий мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмж, бараа материалыг Онцгой байдлын ерөнхий газрын үндсэнд хөрөнгөнд бүртгэв.

НОБГ-т Япон улсын буцалтгүй тусламжаар "Улаанбаатар хотын үерийн эрсдлийн менежментийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд үерийн гамшгийн үед ашиглагдах тусгай зориулалтын багаж хэрэгсэл, хувцас, суурин болон гар станц, хөдөлмөр хамгааллын хувцас, байршил тодорхойлогч, шуурхай штабын байрны тоноглол зэрэг 43 нэр төрлийн 1,02 тэрбум төгрөгийн өртөг бүхий багаж хэрэгслээр хангагдсан.

Засгийн газрын 2015 оны 167 дугаар тогтоолын дагуу улсын хэмжээнд ой, хээрийн түймэр гарах давтамж нэмэгдэж байгаатай холбогдуулан түймрийн голомтонд үүрэг гүйцэтгэж байгаа онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдад нэн шаардлагатай байгаа хүн нэг бүрийн хамгаалалтын хувцас хэрэглэл, гал унтраах багаж зэвсэглэмж худалдан авах зардалд 600,0 сая төгрөг батлуулснаас 480,0 сая төгрөгний бараа материал, мөн оны 6 дугаар сард төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Шадар сайд, Сангийн сайд, Хөгжлийн банкны хооронд байгуулсан гэрээний дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 20,0 тэрбум төгрөгний гал унтраах, аврах ажиллагааны зориулалттай 29 нэр төрлийн 18,9 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэв.

2015 онд төсвийн урсгал зардлаар нормын хувцас хэрэглэлийн худалдан авалтад нийт 2.9 тэрбум төгрөгийг зарцуулан 40 нэр төрлийн 102,300 ширхэг нормын хувцас, хэрэглэл худалдан авав.

Монгол Улсын Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан "Онцгой байдлын албаны техник, тоног төхөөрөмж" төсөл арга хэмжээнээс хэмнэгдсэн 1,2 тэрбум төгрөгийг "Гамшгийн удирдлагын командын байр"-ны санхүүжилтэд зарцуулах ЗГ-ын 304 дүгээр тогтоолын дагуу тус барилгыг барьж ашиглалтанд оруулахад бэлэн болоод байна.

ОБЕГ, Бүгд Найрамдах Австри Улсын Розенбаур Интернейшнл Аг компанийн хооронд байгуулсан "Монгол улсын гал түймэртэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх хүрээнд аврах, гал унтраах ажиллагааны автомашин, дагалдах хэрэгслийг нийлүүлэх" гэрээний хүрээнд 5,1 сая еврогийн өртөгтэй 16 автомашиныг хүлээн авахад бэлэн болоод байна.

5.5.Аврах ажлын зарим багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх, засварлах нөхцөлийг бүрдүүлэх:

Орон нутагт аврах, гал унтраах ажиллагааны техникийн агрегатын их засварын ажлыг хийхэд ашиглах зориулалттай 1 тоннын даацтай угсардаг өргөх механизм 1

ширхэгийг дотооддоо үйлдвэрлэн туршилтын журмаар ашиглаж байна. Мөн өвлийн улиралд автомашины халаалтын уурын тогоо угсрах, автомашиныг хазгай, налуу газар ажиллах боломжийг бүрдүүлэх ивүүр зохион бүтээсэн.

Агрегатын засварын оношилгоо, үзлэг хийх онол, дадлага сургалтыг Сүхбаатар, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт бүсчлэн зохион байгуулсан. Мөн дадлага сургалтыг 2014 оны 11-12 дугаар сард Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгуудад зохион байгуулсан.

Онцгой байдлын албанд ашиглагдаж байгаа аврах ажлын зарим багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг засварлах төвийг Онцгой байдлын ерөнхий газрын Автобаазыг түшиглэн байгуулахаар мэргэжлийн төсөвчинд хандан зураг хийлгэсэн бөгөөд хөрөнгийн боломжгүйгээс зогссон.

5.6.Улсын нөөцийн бараа, материалыг хадгалах нөхцөл, технологийг дээшлүүлэх

2012-2014 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 6,9 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлэн төв, орон нутгийн Улсын нөөцийн салбарт барилга байгууламж шинээр барих, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн засварлах ажлууд хийгдэж, 828,8 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авч олгосон болно.

Улаанбаатар хотод сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийн евро стандартын шаардлага хангасан улсын нөөцийн хүнсний бүтээгдэхүүн хадгалах 20,0 мянган тонн дулаан, 2,0 мянган тонн хөргүүртэй иж бүрэн механикжсан агуулах болон газрын тосны бүтээгдэхүүний 20,0 мянган метр.кубын багтаамжтай терминал агуулахыг тус тус шинээр барьж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Энэ хүрээнд:

1. Агуулах барих газрын асуудлыг шийдвэрлүүлж, газар эзэмших зөвшөөрлийг аван 2013 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дээрх агуулахын зураг, төслийг хийлгэсэн.

2. Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөр зураг, төслийг хянуулан баталгаажуулсан.

3. Холбогдох газруудаас агуулах барих техникийн нөхцлүүдийг авч, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудтай хамтран ажиллаж байна.

Төв, орон нутгийн Улсын нөөцийн салбаруудын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах, нөөцийн бараа, материалыг технологийн дагуу хадгалах, хамгаалах нөхцлийг сайжруулах зорилгоор 2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 278.4 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж (өвс хаман боогч машин, авто өргөгч, мотопомп, насос)-ийг худалдан авсан.

5.7.Гамшгийн нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх, зөвлөмж өгөх гамшгаас хамгаалах менежментийн үндэсний шинжээч болон гадаад улсад хүмүүнлэгийн үүрэг гүйцэтгэх аврах багийг бэлтгэх:

Монгол Улс эрэн хайх, аврах үндэсний багийн чадавхийг үнэлэх, дэлхий дахинд тохиолдсон томоохон гамшгийн дараах эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох итгэмжлэгдсэн багийг байгуулах тухай хүсэлтийг НҮБ-ын Эрэн хайх, аврах олон улсын зөвлөлдөх бүлэгт илэрхийлсний дагуу тус зөвлөлдөх бүлгээс үнэлгээний баг 2014 оны 10 дугаар сард Монгол Улсад ажиллаж, 5 зүйлийн 21 зөвлөмжийг өгсөн. ОБЕГ-ын даргын 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/78 тоот тушаалаар тус зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

5.8.Гамшгаас хамгаалах улсын албадын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чадавхийг сайжруулах:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 186 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах улсын 13 алба ажиллаж байсныг Засгийн газрын 2015 оны 81 дүгээр тогтоолоор гамшгаас хамгаалах улсын 12 алба болгож шинэчлэн ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах улсын албадын удирдах бүрэлдэхүүний сургалтыг жил бүр зохион байгуулж байгаа (2012 оноос 8 удаа) бөгөөд 2015 онд албадын гамшгаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын уулзалт, зөвлөгөөн, ОБЕГ-ын дэд дарга, ЭМСЯ-ны төрийн нарийн бичгийн даргын хамтран баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн улсын албаны 19 удирдах ажилтан оролцсон сургалт, дадлагыг “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдэл” сэдвээр тус тус зохион байгуулсан.

---oOo---